



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 7 сарын 08 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

### Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Хас-Үнэлгээ” ХХК-д Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Арслан хотхон, 15-1-7 тоотод төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.

2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Хас-Үнэлгээ” ХХК /Л.Нямбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН